# МОНГОЛ УЛСЫН
# ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН
# ТУШААЛ

2025 оны 06 сарын 12 өдөр Дугаар А/242 Улаанбаатар хот

Эмнэлгийн тусламж, үйлчилгээний чиглэл,
хүрээ шинэчлэн батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.3, 8.1.13 дэх заалт, 8.8 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улсын хэмжээнд эрүүл мэндийн бусад байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь”-ыг нэгдүгээр, “Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ”-г хоёрдугаар, “Зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ”-г гуравдугаар, “Нийслэлд гемодиализийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ”- дөрөвдүгээр хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалыг хэрэгжүүлж, мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх хүрээний эрүүл мэндийн байгууллагын тусламж, үйлчилгээний чадавхыг сайжруулах, иргэнд хүлээгдэл, чирэгдэлгүй үзүүлэхэд чиглэсэн арга хэмжээг зохион байгуулахыг Улсын нэгдүгээр төв эмнэлэг /Л.Бямбасүрэн/, Улсын хоёрдугаар төв эмнэлэг /Б.Бямбадорж/, Улсын гуравдугаар төв эмнэлэг/Ц.Төмөр-Очир/-т тус тус даалгасугай.

3. Тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллахыг өмчийн бүх хэлбэрийн эрүүл мэндийн байгууллага, улсын хэмжээнд мэргэжил аргазүйгээр хангаж ажиллахыг төрөлжсөн мэргэшлийн эмнэлгийн дарга, захирал нарт үүрэг болгосугай.

4. Нийслэлийн харьяа эрүүл мэндийн байгууллагын гемодиализийн тусламж, үйлчилгээний нэгдсэн зохицуулалтыг хангаж, хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн эрүүл мэндийн газар /Х.Бат-Ирээдүй/-т үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Салбарын хяналтын газар/О.Энхболд/, Эмнэлгийн тусламжийн бодлогын газар/Р.Гантуяа/-т тус тус үүрэг болгосугай.

6. Энэхүү тушаал батлагдсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2020 оны 03 дугаар сарын 04-ний өдрийн “Үйлчлэх хүрээ батлах тухай” А/154 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2022 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн “Хуваарь батлах тухай” А/344 дүгээр тушаал, Эрүүл мэндийн сайдын 2014 оны 08 дугаар сарын 11-ний

141251378

өдрийн “Алсын дуудлага, явуулын эмнэлгийн талаар авах арга хэмжээний тухай” 263 дугаар тушаалын Журмын хавсралт нэг, тушаалын хоёрдугаар хавсралт, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн “Жагсаалт, журам батлах тухай” А/485 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан “Эмнэлгийн мэргэшсэн тусламж, үйлчилгээ үзүүлэх журам”-ын “Улсын хэмжээнд эрүүл мэндийн бусад байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь”, Эрүүл мэндийн сайдын 2017 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн “Журам, хуваарь батлах тухай” А/119 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙДЫН ҮҮРЭГ
ГҮЙЦЭТГЭГЧ Т.МӨНХСАЙХАН

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар
сарын 12-ны өдрийн А/242 дугаар тушаалын
нэгдүгээр хавсралт

**Улсын хэмжээнд эрүүл мэндийн бусад байгууллагыг арга зүйгээр хангах тусламж, үйлчилгээний хуваарь**

| № | Эрүүл мэндийн байгууллага | Төрөлжсөн мэргэшлийн тусламж, үйлчилгээний чиглэл |
|---|---|---|
| 1. | Арьсны өвчин судлалын үндэсний төв | Арьс, харшил, эмчилгээний гоо заслын тусламж, үйлчилгээ |
| 2. | Гэмтэл согог судлалын үндэсний төв | Гэмтэл согог, түлэгдэлт, осголт, хөлдөлтийн тусламж, үйлчилгээ<br>Спортын гэмтлийн тусламж, үйлчилгээ |
| 3. | Халдварт өвчин судлалын үндэсний төв | Халдварт өвчний тусламж, үйлчилгээ<br>Дархлаажуулалт, халдвар судлалын лабораторийн тусламж, үйлчилгээ |
| 4. | Хавдар судлалын үндэсний төв | Бүх төрлийн хавдрын тусламж, үйлчилгээ<br>Хавдрын туяа эмчилгээ<br>Хавдрын хөнгөвчлөх, хими эмчилгээ, өвдөлт намдаах тусламж, үйлчилгээ |
| 5. | Сэтгэцийн эрүүл мэндийн үндэсний төв | Сэтгэц, зан үйлийн тусламж, үйлчилгээ<br>Донтох эмгэгийн тусламж, үйлчилгээ |
| 6. | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Хүүхдийн зүрх, бөөр, мэдрэл, цусны хавдар, дотоод шүүрэл, хоол боловсруулах эмгэг эмгэгийн тусламж, үйлчилгээ<br>Хүүхдийн эрхтэн шилжүүлэх, зүрх, цээжний хөндий, бөөр, нүд, чих, хамар, хоолой, мэс заслын тусламж, үйлчилгээ<br>Нярай, ургийн мэс засал, эрчимт эмчилгээний тусламж үйлчилгээ<br>Эмэгтэйчүүдийн тусламж, үйлчилгээ<br>Жирэмсэн, төрөх, төрсний дараах үеийн тусламж, үйлчилгээ<br>Эх, ургийн анагаах ухааны тусламж, үйлчилгээ<br>Эрсдэлтэй жирэмсэн, дутуу тээлт, дутуу төрөлтийн тусламж, үйлчилгээ<br>Анагаахын удам зүйн тусламж, үйлчилгээ |
| 7. | Эх, нярай, эмэгтэйчүүдийн үндэсний төв-II | Хүүхдийн эрчимт эмчилгээний тусламж, үйлчилгээ<br>Хүүхдийн яаралтай тусламж, үйлчилгээ<br>Хүүхдийн уушгины эмгэгийн тусламж үйлчилгээ<br>Нярайн тусламж, үйлчилгээ<br>Хүүхдийн ерөнхий мэс заслын тусламж үйлчилгээ<br>Эмэгтэйчүүдийн хавдрын хөнгөвчлөх тусламж, үйлчилгээ |
| 8. | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Цус, цус төлжүүлэх эрхтэн тогтолцооны эмгэг, цусны хавдрын тусламж, үйлчилгээ<br>Эрүү нүүрний мэс заслын тусламж, үйлчилгээ |

| | | |
|---|---|---|
| | | Яс, үе булчингийн тогтолцооны эмгэгийн тусламж, үйлчилгээ<br>Цөмийн анагаах ухааны оношилгоо эмчилгээний тусламж, үйлчилгээ<br>Радиоиммунологийн оношилгооны тусламж, үйлчилгээ<br>Эс, эд, эрхтэн шилжүүлэх тусламж, үйлчилгээ |
| 9. | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Цөмийн анагаах ухааны оношилгоо эмчилгээний тусламж, үйлчилгээ |
| 10. | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Зүрх, судасны мэс заслын тусламж, үйлчилгээ<br>Тархи, нуруу нугас, хүүхдийн мэдрэлийн мэс заслын тусламж, үйлчилгээ |
| 11. | Цэргийн төв эмнэлэг | Цацраг идэвхт, химийн болон эмийн бодисын хурц хордлогын тусламж үйлчилгээ;<br>Галт зэвсгийн гэмтлийн тусламж үйлчилгээ; |
| 12. | Уламжлалт анагаах ухаан технологийн хүрээлэн | Уламжлалт анагаах ухааны тусламж, үйлчилгээ |
| 13. | Зоонозын өвчин судлалын үндэсний төв | Зоонозын халдварт өвчний тархвар судлалын шуурхай хариу арга хэмжээ, лабораторийн тусламж, үйлчилгээ |
| 14. | Цус сэлбэлт судлалын үндэсний төв | Цус сэлбэлт судлалын тусламж, үйлчилгээ |
| 15. | Эмгэг судлалын үндэсний төв | Эмгэг судлалын тусламж, үйлчилгээ |
| 16. | Геронтологийн үндэсний төв | Настаны эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ |

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн А/242 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

## Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ

| | Мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх эрүүл мэндийн байгууллага | Орон нутгийн эрүүл мэндийн байгууллага | |
|---|---|---|---|
| | | Нийслэлд | Аймагт |
| 1. | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Сүхбаатар дүүрэг<br>Чингэлтэй дүүрэг<br>Хан-Уул дүүрэг<br>Өргөө амаржих | Дундговь аймаг<br>Өвөрхангай аймаг<br>Архангай аймаг<br>Говь-Алтай аймаг<br>Баянхонгор аймаг,<br>Төв аймаг<br>Өмнөговь аймаг |
| 2. | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Баянзүрх дүүрэг<br>Налайх дүүрэг<br>Багануур дүүрэг<br>Багахангай дүүрэг<br>Амгалан амаржих газар | Дорнод аймаг<br>Сүхбаатар аймаг<br>Хэнтий аймаг<br>Говьсүмбэр аймаг<br>Дорноговь аймаг |
| 3. | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Сонгинохайрхан дүүрэг,<br>Баянгол дүүрэг,<br>Хүрээ амаржих газар | Ховд аймаг<br>Увс аймаг<br>Баян-Өлгий аймаг<br>Завхан аймаг,<br>Хөвсгөл аймаг<br>Булган аймаг<br>Орхон аймаг<br>Сэлэнгэ аймаг<br>Дархан-Уул аймаг |

**Жич:**

1. Эмнэлэг хооронд өвчтөн шилжүүлэхэд "Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ"-ний дагуу зохицуулагдана.

2. Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг нь өөрийн хүчин чадлаас давсан эмнэлгийн тусламж шаардлагатай болсон үйлчлүүлэгчийн харьяаллын дагуу мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагатай, тухайн байгууллагын хүчин чадлаас давсан бол Улсын хэмжээнд арга зүйгээр хангах эрүүл мэндийн байгууллагатай хамтран тусламж, үйлчилгээний тасралтгүй байдлыг хангаж ажиллах арга хэмжээг авна.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар
сарын 12-ны өдрийн А/242 дугаар тушаалын
гуравдугаар хавсралт

## Зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ

| № | Зүрхний шигдээсийн үед судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллага | Хамрах хүрээ | Мэргэжил аргазүйн дэмжлэг үзүүлэх төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг |
|---|---|---|---|
| 1. | Дорнод аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв | Сүхбаатар аймаг | Улсын хоёрдугаар төв эмнэлэг |
| 2. | Хэнтий аймгийн Нэгдсэн эмнэлэг | | |
| 3. | Өвөрхангай аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв | Баянхонгор аймаг<br>Архангай аймаг | Улсын нэгдүгээр төв эмнэлэг |
| 4. | Өмнөговь аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв | Харьяалах нутаг дэвсгэрийн хүн амд | |
| 5. | Орхон аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв | Булган аймаг<br>Хөвсгөл аймаг | Улсын гуравдугаар төв эмнэлэг |
| 6. | Ховд аймаг дахь Бүсийн оношилгоо, эмчилгээний төв | Увс аймаг<br>Баян-Өлгий аймаг<br>Говь-Алтай аймаг | |
| 7. | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Сүхбаатар дүүрэг<br>Чингэлтэй дүүрэг<br>Хан-Уул дүүрэг | |
| 8. | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Дорноговь аймаг<br>Баянзүрх дүүрэг<br>Налайх дүүрэг<br>Багануур дүүрэг | |
| 9. | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Завхан аймаг<br>Дархан-Уул аймаг<br>Сэлэнгэ аймаг<br>Сонгинохайрхан дүүрэг<br>Баянгол дүүрэг | |
| 10. | Монгол-Япон эмнэлэг | Дундговь аймаг | |
| 11. | Цэргийн төв эмнэлэг | Говьсүмбэр аймаг<br>Төв аймаг | |

**Жич:**

1. Зүрхний шигдээсийн үеийн судсан дотуурх оношилгоо, эмчилгээ хийх эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас давсан болон тусламж, үйлчилгээ үзүүлэх боломжгүй нөхцөл үүсэхэд "Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээнд мэргэжил, арга зүйн дэмжлэг үзүүлэх хүрээ"-ний дагуу үйлчлүүлэгчийг шилжүүлнэ.
2. Иргэн тусламж, үйлчилгээ авахаар сонгон очсон тохиолдолд тухайн эрүүл мэндийн байгууллага дээрх хүрээ хамаарахгүй тусламж, үйлчилгээг үзүүлнэ.

Эрүүл мэндийн сайдын 2025 оны 06 дугаар
сарын 12-ны өдрийн А/242 дугаар тушаалын
дөрөвдүгээр хавсралт

**Нийслэлд гемодиализийн тусламж, үйлчилгээг үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын үйлчлэх хүрээ**

| № | Эрүүл мэндийн байгууллага | Бусад эрхтэн системийн эмгэг хавсарсан бөөрний архаг болон цочмог дутагдлын үеийн тусламж | Бөөрний архаг дутагдлын үеийн тусламж |
|---|---|---|---|
| 1 | Улсын нэгдүгээр төв эмнэлэг | Мэргэжил аргазүйгээр хангах аймгууд болон Чингэлтэй дүүргийн иргэд | Чингэлтэй дүүрэг |
| 2 | Улсын хоёрдугаар төв эмнэлэг | Мэргэжил аргазүйгээр хангах аймгуудын иргэд | Үйлчлэх хүрээний албан тушаалтан |
| 3 | Улсын гуравдугаар төв эмнэлэг | Мэргэжил аргазүйгээр хангах аймгуудын иргэд | - |
| 4 | Эх, хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв | Хүүхэд, жирэмсэн эмэгтэйчүүд | |
| 5 | Хавдар судлалын үндэсний төв | Хавдартай иргэд | |
| 6 | Цэргийн төв эмнэлэг | Үйлчлэх хүрээний иргэд | |
| 7 | Төрийн тусгай албан хаагчдын Нэгдсэн эмнэлэг | Үйлчлэх хүрээний иргэд | |
| 8 | АШУҮИС-ийн Монгол-Японы эмнэлэг | Үйлчлэх хүрээний иргэд | |
| 9 | Сонгинохайрхан дүүргийн Эрүүл мэндийн төв | Сонгинохайрхан дүүргийн иргэд | |
| 10 | Сонгинохайрхан дүүргийн Нэгдсэн эмнэлэг | | |
| 11 | Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төв | Баянгол дүүргийн иргэд | |
| 12 | Хан-Уул дүүргийн Эрүүл мэндийн төв | Хан-Уул дүүргийн иргэд | |
| 13 | Сүхбаатар дүүргийн Нэгдсэн эмнэлэг | Сүхбаатар дүүргийн иргэд | |
| 14 | Баянзүрх дүүргийн Нэгдсэн эмнэлэг | Баянзүрх дүүргийн иргэд | |
| 15 | Багануур дүүргийн Эрүүл мэндийн төв | Багануур дүүргийн иргэд | |
| 16 | Налайх дүүргийн Эрүүл мэндийн төв | Налайх, Багахангай дүүргийн иргэд | |
| 17 | Гемодиализийн тусламж, үйлчилгээ үзүүлж байгаа хувийн хэвшлийн эмнэлэг | Төрөлжсөн мэргэшлийн эмнэлэг, дүүргийн эрүүл мэндийн байгууллагын хүчин чадлаас давсан/ хүлээгдэлд байгаа иргэд болон өөрийн хүсэлтээр сонгосон иргэд | |

**Жич:**

- Эрүүл мэндийн байгууллага нь үйлчлэх хүрээний иргэдэд гемодиализийн эмчилгээг хүртээмжтэй, чанартай үзүүлэхэд хяналт тавьж, асуудлыг шийдвэрлэнэ.
- Байгууллагын хүчин чадлаас давсан тохиолдолд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагатай зөвшилцөн, үйлчлүүлэгчийн эмчилгээний тасралтгүй байдлыг хангах арга хэмжээг авна.